

ДЭЛХИЙН ХҮН АМЫН ӨДӨРТ ЗОРИУЛАВ

НҮБ-ын Хүн Амын Сангаас жил бүр “Дэлхийн хүн амын байдал” тайлан илтгэлийг бэлтгэн хэвлүүлдэг юм. Дэлхийн Хүн Амын өдөр 7 дугаар сарын 11-нд зориулан бид энэ удаагийн дугаараараа “Дэлхийн хүн амын байдал-2007” тайлан илтгэлийн хураангуйг уншигч танд толилуулж байна.

Тайлан илтгэлийн сэдэв: “Хотжилтын нөөц бололцоог ашиглах нь”

2008 онд дэлхийн түүхэнд анх удаа хүн төрөлхтний талаас илүү буюу 3.3 тэрбум хүн хот суурин газар амьдрах болно. Энэ тоо 2030 он гэхэд ойролцоогоор 5 тэрбумд хүрч нэмэгдэх төлөвтэй байна. Ялангуяа Африк, Азийн хотын хүн ам 2000-аас 2030 оны хооронд хоёр дахин өснө. Хотын иргэдийн олонхи нь ядуу байх болно. Тэрхүү өсөлтийг урьдчилан харж, бэлтгэх зорилгоор өнөөдөр гаргасан шийдвэрээс хотын ядуучууд, хөгжиж буй орнуудын хотууд, түүнчлэн хүн төрөлхтний ирээдүй ихээхэн хамаарна.

Хотжилт мянган жилийн босгон дээр

Хотжилт /нийт хүн амын дотор суурин хүн амын эзлэх хувь/ нэмэгдэх нь зайлшгүй бөгөөд энэ нь зэрэг нөлөөтэй байж болох талтай. Өнөө үед хот сууринд газар авсан ядуурал, ядуучуудын хороолол, нийгмийн тэгш бус байдал санаа зовоож байгаа ч аж үйлдвэр хөгжсөн улс болгон хотжилтын тусламжтайгаар эдийн засгаа өсгөсөн билээ. Хот ядуурлыг төвлөрүүлдэг ч нөгөө талаас ядуурлаас гарах хамгийн их бололцоо тэнд л бий. Хүн амыг хотод төвлөрүүлснээр урт хугацааны тогтвортой байдлыг хангахад нөлөөлнө. Хэдийгээр хот байгаль орчинд хөнөөл учруулсан ч эргээд шийдвэрлэх аргыг эрэлхийлж байдаг. Хотжилтыг дагалдах давуу тал сул талаас олон байдаг. Харин эдгээр давуу талыг олж, хүнд хэрэгтэй байдлаар ашиглах нь тулгамдсан асуудал болоод байна.

Хотод ядуурал, орон сууц, байгаль орчин, удирдлага зохион байгуулалтын гээд олон тулгамдсан асуудал байгаа боловч

хотын хүн амын өсөлттэй холбоотой ирээдүйд гарах асуудалтай харьцуулахад ач холбогдол нь бага мэт санагдана. Асуудал гарсан үед гал унтраах маягаар арга хэмжээ авах нь цаашид хангалтгүй, харин урьдчилж шийдвэрлэх зарчимд шилжих хэрэгтэй байна.

Энэ тайлан илтгэл нь ирээдүйд бэлтгэсэн арга хэмжээнд дуудсан уриалга юм. Хот суурингийн хүн ам богино хугацаанд нэмэгдсэнээр гарах үр дагаврыг таамаглах, тэдгээрийг шийдвэрлэхэд бэлтгэх, ядуурлыг бууруулан, тогтвортой байдлыг хангахын тулд юу хийх ёстойг тайлан илтгэлд авч үзсэн байна.

Хэдийгээр том хотууд үргэлж анхаарлын төвд байдаг боловч жижиг хот суурингийн хүн ам хамгийн ихээр өсөх төлөвтэй байна. Тэдний бололцоо чадавхийг бэхжүүлэх нь зайлшгүй чухал асуудал болоод байна.

Бодлого боловсруулагчид, иргэний нийгмийн зүгээс одоо авч хэрэгжүүлэх бодлогын зөв арга хэмжээ хот суурингийн хүн амын өсөлтөөс үүдэн гарах нийгмийн, байгалийн, амьжиргааны нөхцөлийг шийдвэрлэхэд нөлөөлнө. Тайлан илтгэл 2 гол дүгнэлтийг гаргаж байгаа бөгөөд үүнд хотын хүн ам өсөхөд түүнд ядуу хүмүүсийн эзлэх хувь маш өндөр байна, түүнчлэн шилжих хөдөлгөөнөөс илүүтэйгээр ердийн өсөлтөөс болж хотын хүн ам өснө.

Энэ хоёр дүгнэлттэй холбоотой бодлогын гурван санаачилга гарч ирж байна. Үүнд:

- Шилжих хөдөлгөөнийг хорих замаар хотын өсөлтийг хязгаарлах гэсэн оролдлогыг зогсоох, ядуу хүмүүсийн хот суурин газарт амьдрах хүсэл сонирхолыг дэмжих;

- Ядуурлыг бууруулж, тогтвортой байдлыг дэмжихийн тулд газрыг хэрхэн ашиглах талаар алсыг харсан, өргөн хүрээтэй бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Хотын ирээдүйд чиглэсэн үйл ажиллагааг одооноос эхлэн нийгмийн хөдөлгөөн, Засгийн газар, олон улсын байгууллагууд хамтран санаачилж, хэрэгжүүлэх.

Их хотын татах хүч

Хот суурингийн өсөлт ХХI зууны хөгжилд нөлөөлөх хамгийн том хүчин зүйл байх боловч хотжилтын сөрөг үр дагаврыг багасгах талаар маш бага зүйл хийгдэж байна. Тайлан илтгэл алсыг харсан шинжилгээ, цагийг сөрсөн арга хэмжээг авахыг уриалж байна. Хүлээгдэж байгаа өсөлт, өөрчлөлт маш түргэн явагдах учраас Засгийн газар болон бодлого боловсруулагчид зөвхөн хариу арга хэмжээ авах нь хангалтгүй юм.

Өнөөгийн хотжих үйл явц их өргөн хүрээтэй явагдаж байгаа бөгөөд хөгжиж буй улс оронд төвлөрч байна. 2000-2030 онд Азийн хот суурингийн хүн ам 1.36 тэрбумаас 2.64 тэрбум, Африкийнх 294 саяас 742 сая, Латин Америк, Кариббийн бүсийнх 394 саяас 609 сая болж өснө.

Даяарчлал буюу дэлхийн эдийн засаг интеграцчлагдах дэвшилтэд үйл явцын гол ашиг хүртэгчид нь хотууд юм. Гэвч маш цөөхөн хот өсөж буй хүн амынхаа хэрэгцээг хангахуйц ажлын байрыг бий болгож байна. Түүнчлэн эмэгтэйчүүд, үндэсний цөөнх гэх мэт нийгэм, эдийн засгийн үр ашгаас хоцордог хүн амын бүлэг хотжилтын эерэг үр дагаврыг жигд хүртэж чадахгүй байна. 10 саяас дээш хүн амтай аварга хотууд 1970-аад онд таамаглаж байсан хэмжээнд хүртэл өсч чадсангүй. Дэлхийн суурин хүн амын 52 хувь нь 500,000-аас доош хүнтэй хотод амьдарч байна. Зарчмын хувьд хотын асуудлуудыг жижиг хотод шийдвэрлэхэд хялбар байдаг боловч, хүн хүчний, санхүүгийн

болон техникийн нөөц багатай байдаг нь хүндрэл учруулдаг юм. Жижиг, ялангуяа 100,000-аас цөөн хүн амтай хотуудад ядуу хүмүүс, ялангуяа эмэгтэйчүүдийн нөхцөл байдал хөдөөгийн ядуу хүмүүсээс дээрдэх зүйл байдаггүй нь харамсалтай баримт болж байна.

Бодлого боловсруулагчид ерөнхийдөө хотын өсөлтийг хязгаарлах, шилжих хөдөлгөөнийг хорих замаар асуудлыг шийдвэрлэх гэж оролддог. Гэвч ийм бодлого нь үр дүнгүй, ядуучуудын орон сууц, амьдрах орчныг орхигдуулснаар ядуучуудын хороолол тэлэхэд хүргэж байна. Хэдийгээр улс орон болгон өөрийн онцлогтой боловч хотын хүн амын өсөлт шилжих хөдөлгөөнөөс илүүтэйгээр хүн амын ердийн өсөлтөөс шалтгаалж нэмэгддэг. Шилжих хөдөлгөөн нь үнэн хэрэгтээ хотын хөгжилд эерэг нөлөө үзүүлдэг юм.

Хот суурин дахь хүмүүс:

Итгэл найдвар – хоосрол

2015 он гэхэд ядуурлыг тэн хагас хүртэл бууруулна гэсэн Мянганы хөгжлийн зорилгод хүрэх тэмцэл гол төлөв ядуучуудын хороололд өрнөх болно. Ерөнхийд нь авч үзвэл том хот суурин ядуурлыг бууруулах илүү их боломжийг олгодог. Гэвч шилжих хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор ядуучуудын асуудлыг шийдвэрлэхгүй орхиж, тэдний нөөц бололцоог тооцохгүй байгаагаас энэ давуу тал ашиглагдахгүй өнгөрч байна. Ийм учраас, хөдөөтэй харьцуулахад хот суурин дахь ядуурал илүү хурдацтай өсөж байна. Өнөөдөр тэрбум орчим хүн ядуу амьдарч байгаа бөгөөд тэдний 90 гаруй хувь нь хөгжиж буй оронд байна.

Ядуу хүмүүс эрүүл бус орчинд амьдардаг. Хүн ам хэт төвлөрсөн, ариун цэвэр муу, цэвэр ус дутмаг, амьдралын болон ажлын орчин агааржуулалт муутай, агаарын бохирдол зэрэг нь эрүүл мэндийн эрсдэлийг бий болгодог. Эдгээр бэрхшээл нь ядуучуудын эрүүл мэндэд,

ялангуяа өрх гэрийнхээ хоол хүнс, цэвэр усыг бэлтгэн, ариун цэврийг сахиж байдаг эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд үзүүлэх таагүй нөлөө, ажлын ачааллыг нэмэгдүүлж, мөн орчны сөрөг нөлөө, гэмт хэрэгт өртөх магадлалыг өсгөж байна. Хот суурингийн орон байрны хангамжийг сайжруулахад чиглэсэн бодлого ядуурлын бууруулах, орчныг зохистой байлгахад ихээхэн нөлөө үзүүлнэ. Хөдөөтэй харьцуулахад хотод боловсрол эзэмших, ажил эрхлэх сонголт эмэгтэйчүүдэд илүү байдаг. Гэвч ядуу өрхүүд энэ бололцоог тэрбур ашиглаж чадахгүй байна. Сургууль хоцорсон хүүхдүүдийн олонхи нь охид, ажил эрхлэх болоход эмэгтэйчүүд хамгийн бага цалин авч, хамгийн баталгаагүй, зохицуулалтгүй албан бус салбарт ажиллаж байна. Хот эмэгтэйчүүдийн нийгмийн болон улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй бөгөөд олон нийтийн байгууллагууд ядуу эмэгтэйчүүдийн амьжиргааг сайжруулах асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлж чадна. Гэвч тэдэнд Засгийн газар, олон улсын байгууллагуудын дэмжлэг шаардлагатай байна.

Эрүүл мэндийн үйлчилгээ хөдөөг бодвол хотод илүү чанартай боловч ядуу эмэгтэйчүүд ийм үйлчилгээг тэр бүр хүртэж чаддаггүй. Тэд хүсээгүй жирэмслэлт, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ, тендерт суурилсан хүчирхийлэлд өртөх илүү магадлалтай байдаг. Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах нь нийт хүн амын амьжиргааг дээшлүүлэх, хүний эрхийг хангах, хотжилттой холбоотой бодлогын боломжуудыг бий болгоно.

Хотжилт соёлын өөрчлөлтөд түлхэц болсон бөгөөд энэ өөрчлөлт нэг хэвийн, амар хялбар байгаагүй. Нийгмийн бүлгүүдийн хоорондох ялгаа улам гүнзгийрч, тэгш бус байдал улам газар авч байна. Хотын амьдрал хүмүүст өөрийгөө илэрхийлэх бололцоог олгож байгаа ч, шашны хуучинсаг үзэл, гэмт хэрэг, хүчирхийлэл гарах нөхцлийг бүрдүүлж байна.

Залуучуудын амжилт, алдаа ирээдүйн хөгжлийг тодорхойлох боловч тэдний хүсэл эрмэлзлийг улс төрийн үйл явцад авч үзэхгүй байна. Олон залуус ядуу амьдарч, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ авч, ажил эрхлэх бололцоогүй байна. Энэ байдал нь ядуурлыг нэмэгдүүлж, сэтгэл түгших, урам хугарах байдлыг үүсгэх бөгөөд хүчирхийлэл, гэмт хэрэг гарах нөхцлийг бүрдүүлж байна.

Дэлхий дахинаа ахимаг настай хүмүүсийн тоо ба хүн амд эзлэх хувь өсөж байна. Хотын амьдрал бусад хүн амын адил тэдэнд боломж олгож байгаа боловч ядуу хүмүүс тэр болгон ашиглаж чадахгүй байна.

Хотын амьдралын боломж, бодит байдлын ялгааг арилгахын тулд хийж болох хамгийн энгийн зүйл бол хотын хүн ам өснө гэдгийг хүлээн зөвшөөрч, асуудлыг нааштайгаар шийдвэрлэхэд оршино. Энэ нь ухуулга нөлөөллийн ажил, улс төрийн хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэхийг шаардаж байна. Засгийн газрууд хотын ядуурлыг бууруулах чиглэлээр ажилладаг олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудтай нягт хамран ажиллах шаардлагатай.

Хот суурингийн ядууралтай тэмцэх бодлогыг дахин эргэцүүлэх нь

Бодлого боловсруулагчид, төлөвлөгч нар хот, суурингийн өсөлтийн эсрэг үзэл баримтлалаас болж төрийн бус байгууллагын оролцоог орхигдуулдаг. Энэ нь буруу мэдээлэл дээр үндэслэсэн буруу стратеги юм. Хүмүүс хотын амьдралын давуу талыг зөн совингоороо мэдрээд нүүж ирдэг бөгөөд ядуурлаас гарахын тулд тэдэнд дэмжлэг хэрэгтэй байдаг. Нэгэнт ядуурлаас гарах юм бол хүмүүс эргээд хотын болон хөдөөгийн эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулах болно.

Байр орон сууцны бэрхшээл хотын ядуурлын төвд байдаг асуудал. Хүн амьдрахад бололцоотой орон байр, хаяг

хотын ядуусын хамгийн чухал хэрэгцээ бөгөөд эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулахад нэн түрүүнд туслах юм. Боломжийн байр орон сууц бол сайн сайхан амьдрах анхны шат юм. Хотын ядуучуудын нилээд хэсэг нь дамын худалдаачдын эзэлсэн газар зах зээлд ороод учраа олохгүй тулгамдаж, эцэст нь хамгийн аюултай газар орогнон суурьшиж, ямар нэгэн байр сав өөрийн хүчээр барьж толгой хорогддог. Орон нутгийн засаг захиргаа наад захын үйлчилгээ үзүүлэх шийдвэр гаргахад эдийн засгийн өртөг нь хэт өндөр, зам тавьж, усны суваг, бохирын систем барихад одоогийн барилга байгууламжийг нураах хэрэг гардаг.

Ийм нөхцөлд өнөөдрийн хэрэгцээнээс гадна ирээдүйн хүн амын өсөлтийг урьдчилан харсан бодлого шаардлагатай юм. Наад захын дэд бүтэцтэй газар өгч эзэмшүүлэх нь асуудлын гол болоод байна. Ядуу хүмүүс өөрийн эзэмшил газартаа аюултай, амьжиргаанд хэрэгцээтэй наад захын үйлчилгээнд хүрэх боломжтой л байх юм бол тэд цаг хугацаа өнгөрөх тусам байдлаа аажмаар сайжруулах л явах болно.

Энэ бол амархан эсвэл төгс шийдэл биш бөгөөд хотын удирдлага зохион байгуулалтад шинэлэг байдлаар хандах шаардлагыг тавьна. Ялангуяа газрын зохицуулалтыг боловсронгуй болгоход анхаарах хэрэгтэй. Гэвч төвийн засаг захиргаа, олон улсын байгууллагын тусламж дэмжлэгтэйгээр энэ бүхнийг шийдвэрлэж болох бөгөөд ялангуяа жижиг хотуудад нэлээд амжилттай явагдаж болох юм. Учир нь жижиг хотод газрын асуудал тийм ч тулгамдсан бус байдаг. Хамгийн гол нь энэ асуудлыг шийдвэрлэснээр ядуу хүмүүсийн сонирхол, оролцоо, хүний эрхийг хангах юм.

Газрыг нийтийн зориулалтаар тогтвортой ашиглах нь

Хотын хүн амын өсөлт араасаа олон асуудал дагуулдаг гэж үздэг боловч, хүн ам нягтарснаар ерөнхийдөө ашигтай гэсэн

ойлголт бий. Харин тэр ашигтай талуудыг хэрхэн зөв зохицуулснаас эерэг үр дүн гарах юм.

Хүн амтай харьцуулахад хот суурин газрын нутаг дэвсгэрийн хэмжээ илүү хурдан томорч байна. 2030 он гэхэд хөгжиж буй улс орнуудын хотын газрын хэмжээ гурав дахин өсөх бөгөөд хөгжингүй орнуудынх 2,5 дахин өснө. Хотын захад суурьшиж амьдрах сонирхолтой хүмүүсийн тоо нэмэгдэж байгаагаар хот суурин газар таруу байрлах хандлагыг тайлбарлаж болно. Хот тэлэхэд нөлөөлж буй бас нэг хүчин зүйл бол дагавар хоттой шууд холбоотой. Дагавар хот нь хөдөөнөөс хот руу шилжих завсрын бүс бөгөөд газар ашиглалтын дүрэм журам, захиргааны зохицуулалт тодорхойгүй байдаг. Эдийн засгийн даяарчлал томоохон байгууламжуудыг том хэмжээний газар байгуулахыг шаардаж байгаа нь дагавар хот бий болох нөхцөлийг бүрдүүлж байна. Тэндхийн хүн ам ядуурал, агаарын бохирдол, байгаль орчны өөрчлөлт гэх мэт хотжилтын хамгийн сөрөг үр дагаврыг амсдаг боловч тэд ажлын байр бий болгож, хотын хүн амын зайлшгүй хэрэгцээ болох хүнс, эрчим хүч, цэвэр ус, барилгын материалаар хангаж байна.

Таруу байрлалыг дэмжих эсэх талаар саналын зөрүү байдаг боловч одоогийн байдлаар бол хотын тогтвортой байдлыг хангахад сөрөг нөлөөтэй гэсэн байр суурь зонхилж байна. Хотжилтой холбоотой асуудлуудыг уялдуулан зохицуулах үл үзэгдэгч гар гэж байхгүй учраас энэ асуудал өөрөө шийдвэрлэгдэхгүй. Тиймээс хотын болон бүсчилсэн хөгжлийн бодлогоо дахин нэг харах шаардлагатай байна. Хэрэгжихэд төвөгтэй том мастер төлөвлөгөө боловсруулсны оронд хотын өсөлтийг гарцаагүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн бүсчилсэн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах нь дээр болоод байна. “Хотын бүс” хэмээх энэ төлөвлөгөө нь хотын ядуучуудын эдийн засаг, нийгэм, байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэхэд туслах болно.

21 дүгээр зууны хотжилт ба тогтвортой байдал

Хотжилтын эерэг үр дагавар өнөөдөр дэлхийн байгаль орчны өөрчлөлттэй холбоотой ямар арга хэмжээ авахаас ихээхэн хамаарч байна. Энэ арга хэмжээ нь зөвхөн орон нутгийн шинж чанартай байх нь хангалтгүй юм. Дэлхийн байгаль орчны өөрчлөлтийг авч үзэх хандлагад орон нутгийн бодлогыг нэгтгэн зангидах бөгөөд орон нутгийн, бүсийн болон үндэсний байгаль орчны асуудлууд ба тэдгээрийн үр дагаврыг цогцоор авч үзэхийг хэлнэ.

Дэлхийн байгаль орчны өөрчлөлтийн үр дагавар урт хугацаанд илрэх учраас орон нутгийн байгаль орчны асуудлыг анхаарах шаардлагыг нэмэгдүүлж байна. Орон нутгийн болон дэлхийн байгаль орчны өөрчлөлтийн урт болон богино хугацааны үр дагаврыг нь ойлгосон бодлого боловсруулагч өөрийн хотын асуудлыг шийдвэрлэж, дэлхийн хэмжээний гэнэтийн асуудалд бэлтгэлтэй байж чадна.

Онгон байгаль болон хөдөө аж ахуйн зориулалт бүхий экосистемийг хот суурин газрын хэрэгцээнд ашиглах явцад үүсэх байгаль орчны тулгамдсан асуудал нь дэлхийн экосистемийн үйл ажиллагаанд чухал нөлөөтэй байдаг. “Хот суурин газрын ул мөр” нь ялангуяа хөгжилтэй улс орнуудад хотын орчин тойронд маш хурдацтайгаар газар авч байна. Их ядуу улс орны хотын байгаль орчны асуудал нь илүүтэйгээр орон нутгийн хэв шинжийг агуулсан байдаг бол томоохон хотуудын асуудал дэлхий нийтийн хамарсан шинжтэй байдаг. Цаг уурын өөрчлөлт ядуу улс орон, хот, хувь хүмүүст хамгийн хүнд тусдаг бөгөөд ялангуяа эрүүл мэнд, цэвэр усны хангамжинд нөлөөлнө. Энэ нэг талаас ядуу улс орнууд халуун орны бүсэд оршдог, нөгөө талаас ядуурлаас болоод хотын байгалийн гамшигт бэлэн байх чадавхи сул байдагтай холбоотой юм.

Маш олон том хот, түүнчлэн хотын хүн амын 13 хувь нь эрэг хавийн бүс нутаг буюу далай, томхон нуур цөөрөм, голын эрэг дээр амьдарч байна. Далайн түвшин дээшилснээр маш их газар нутагт хүн амьдрах бололцоогүй болно. Үүнд зөвхөн эдийн засгийн огцом өсөлтдөө анхаараад байгаль орчны өөрчлөлттэй холбоотой үр нөлөөгөөс өөрийгөө хамгаалах бодлогогүй орнууд өртөх магадлалтай байна. Цаг уур, байгаль орчны өөрчлөлттэй холбоотой орон нутгийн бололцоо, нөхцөлд тохирсон төлөвлөгөөг боловсруулахад хүргэж байна. Хотууд туршлагаасаа хуваалцан, орон нутгийн чадавхийг бэхжүүлж байна. Цаашид ийм түншлэл нь улс төрийн хүрээнд нөлөөтэй байж болох юм. Байгаль цаг уурын өөрчлөлтийг хотууд өргөн хүрээтэй авч үзэж, өөрийн хувь нэмрийг оруулах ёстой. Алсыг харсан бодлого, зөв төлөвлөгөөтэй байснаар эдгээр өөрчлөлтийн сөрөг үр нөлөөг бууруулах боломжтой.

Хотын тогтвортой ирээдүйн төлөв: Бодлого, мэдээлэл ба удирдлага

Хотжилт нь ядуурал, жендэрийн тэгш бус байдлыг бууруулах, тогтвортой хөгжлийг дэмжих зэрэг чухал боломжуудыг бий болгодог. Гэсэн хэдий ч, хүн амын тоо их хэмжээгээр нэмэгдэнэ хэмээн урьдчилан бэлтгэж үр дүнтэй арга хэмжээ авахгүй бол амьдрах орчин нөхцөл улам бүр доройтох болно. Хотын удирдлагыг сайжруулна гэдэг нь орон нутгийн хэрэгцээг хангахад Засгийн газрын хариуцлагыг нэмэгдүүлээд зогсохгүй иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино. Харин өнөөдөр зөвхөн одоогийн хэрэгцээнээс гадна ирээдүйд урган гарах хэрэгцээг таамаглаж арга хэмжээ авахыг хэлж байна.

Орон нутгийн засаг захиргаа нийгмийн салбарт үргэлж сул хэмээн тооцогддог. Гэвч төвлөрлийг сааруулах үйл явц, орон нутгийн иргэний нийгмийн байгууллагын оролцоо нэмэгдсэнээр тэднээс илүү ихийг хүсэж байна. Суурин хүн амын тал хувь

нь оршин сууж буй жижиг хотууд газар ашиглалт, дэд бүтэц, үйлчилгээ зэрэг эгзэгтэй асуудлуудыг шийдвэрлэхэд уян хатан байх давуу талтай. Нөгөө талаар, тэд нөөц бололцоо болон санхүүжилтээр хомс байх хандлагатай байдаг. Тэдэнд мөн шаардлагатай мэдээлэл, түүнийгээ ашиглах техникийн хүчин чадал дутмаг байдаг.

Олон улсын байгууллагууд өөрийн туслалцааг хөгжиж буй улс орнуудын төлөвлөгөө болон бодлого боловсруулагчдад хотжилтоос зайлсхийх аргагүй гэдгийг ойлгуулж, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлсэн, санаачлагатай арга хэмжээ авахуулахад нөлөөлөх замаар үзүүлж чадна. Мөн шилжих хөдөлгөөнийг хязгаарлах нь үр дүнгүй, харин ядуурлыг бууруулах, эмэгтэйчүүдийн эрхийг хангах, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах замаар хотын өсөлтийг зохицуулж болно гэдгийг харуулж чадна.

Өргөжиж буй хот суурин газрын нийгэм болон байгаль орчинд гарч буй өөрчлөлтийг үр дүнтэйгээр зохицуулж удирдахын тулд найдвартай бөгөөд цаг тухайн шинэ мэдээлэл, дүн шинжилгээ шаардлагатай. Ядуу бөгөөд шилжин ирэгсдийн олонхи нь хотын бодлого боловсруулагчдын нүдэнд сайн өртөж чаддаггүй бөгөөд сургууль болон эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй байх, нийгмийн алслагдмал байдлыг үүсгэнэ гэсэн үг юм. Хотын ядуучуудын төлөөллийг оролцуулсан иргэний нийгмийн байгууллагууд нь ийм мэдээллээр хангах боловч үр дүнтэй байхын тулд иргэний нийгмийн байгууллагад мэдээлэл бас хэрэгтэй байна. Засгийн газар болон хандивлагчид орон нутгийн засаг захиргаа, бодлого боловсруулагчдад зөв, цагаа олсон, хэрэгтэй бүлгээр ангилсан мэдээлэл ямар чухал болохыг тэр боолгон ойлгодоггүй. Байгаа мэдээллээ үр дүнтэй ашиглахын тулд хотуудад мэргэшсэн боловсон хүчин шаардлагатай байна.

НҮБ-ын Хүн амын сан болон хүн амын шинжээчид энэ салбарт их зүйл хийж чадах бөгөөд жижиг хотуудад тогтвортой байдлыг хангах, ядуурлыг бууруулах илүү өргөн бололцоог олгох болно.

Орчуулж бэлтгэсэн: НҮБ-ын Хүн Амын Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар